



# ЖИЛИЙН ТАЙЛАН

2017 оны 1-12 сар

Энх тайвны өргөн чөлөө 30-1, Баянзүрх Дүүрэг  
Улаанбаатар, Монгол улс  
Утас: 976-11-461-145

## Агуулга

<b>Товчилсон үгс</b>	<b>3</b>
<b>Танилцуулга</b>	<b>4</b>
Бидний эрхэм зорилго	4
Төслийн багц	4
Төслийн хамрах хүрээ	4
<b>2017 оны гол амжилтууд</b>	<b>5</b>
Үр шим хүртэгчид	5
Хөтөлбөрийн онцлох үйл явдал	6
<b>1. Даван Туулах, Дасан Зохицох Чадвартай Орон Нутгийн Иргэд Хөтөлбөр (RCP)</b>	<b>8</b>
Хөтөлбөрийн тойм	8
Үйл ажиллагаа	9
<b>2. Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь 2 төсөл (LTS2)</b>	<b>15</b>
Төслийн тойм	15
Үйл ажиллагаа	16
Цаг агаарын урьдчилсан мэдээлэл хүргэх үйлчилгээ	16
Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд (LEGS)	17
<b>Гамшгаас хамгаалах бусад төслүүд</b>	<b>20</b>
Үйл ажиллагааны тойм	20
Үйл ажиллагаа	20

# Товчилсон үгс

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЗБДС	Зээлийн Батлан Даалтын Сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУХА	Олон улсын хөгжлийн агентлаг
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
JICA	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг
LEGS	Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд
LEWS	Бэлчээрийн Мал Аж Ахуйн Эрсдлийг Урьчилан Мэдээлэх Тогтолцоо
LTS2	Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах төсөл – 2
LTT4R	Орон нутгийн даван туулах чадавхийг сайжруулахад уламжлалт болон шинэ технологийг ашиглах нь
OFDA	Гамшигт Нэрвэгдсэн Гадаад Орнуудад Тусламж Үзүүлэх Алба
RCP	Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөр

# Танилцуулга

## Бидний эрхэм зорилго

Мерси Кор Монгол ОУБ нь иргэдэд хямралыг даван туулах, амьдралаа дээшлүүлэх, нийгмээ өөрчлөхөд нь дэмжлэг үзүүлдэг. Мерси Кор 40 гаруй улс оронд зоригтой шийдлүүдийг хэрэгжүүлсэнээр хүмүүст бэрхшээлийг давах, хөгжих, чадавхжихад нь тусалдаг.

Мерси Корын эрхэм зорилго нь орон нутгийн иргэдийг хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй нөхцөлд даван туулах дасан зохицох чадварыг эзэмшихэд дэмжлэг үзүүлэхэд оршино. Олон нийтийн идэвхтэй оролцоо нь хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг дэмжиж, сайн засаглалыг бэхжүүлж, байгаль орчныг удирдлагыг хөгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг тул төр, хувийн хэвшлийн харилцаа холбоо, түншлэл нь бидний ажлын үндэс суурь болдог.

## Төслийн багц

2017 онд Мерси Кор байгууллага нь Монгол улсын гамшгийн эрсдлийн удирдлага, байгаль орчны хамгаалал, эдийн засгийн хөгжлийн салбаруудад хувь нэмрээ оруулан ажиллалаа. Төслийн үйл ажиллагааны багц мэдээллийг доорхи хүснэгтээс харна уу.

### Хүснэгт 1: Мерси Корын 2017 онд хэрэгжүүлсэн төслийн мэдээлэл

Төсөл	Хандивлагч байгууллага	Хэрэгжих хугацаа	Хамрагдсан аймгийн тоо
Бусад тусламж	ХХААБ	2017 оны 3-р сар	4
LTS2 (Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь 2 төсөл)	АНУ-ын ОУХА / OFDA	2016 оны 5-р сар – 2017 оны 6-р сар	16
LTT4R (Орон нутгийн даван туулах чадавхийг сайжруулахад уламжлалт болон шинэ технологийг ашиглах нь төсөл)	EX/ECHO	2017 оны 9 сар – 2018 оны 12 сар	4
RCP (Даван Туулах, Дасан Зохицох Чадвартай Орон Нутгийн Иргэд хөтөлбөр)	Мерси Кор	2017 оны 4 сар – 2019 оны 12 сар	8

## Төслийн хамрах хүрээ

Мерси Кор нь 11 аймагт үйл ажиллагаа явуулж байна. Удирдах төв байгууллага нь Улаанбаатар хотод байрладаг. Төслийн хамрах хүрээг бүс нутгаар ангилсаныг доороос харна уу. 2017 онд Мерси Кор нь Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь гэсэн 6 аймаг дахь төлөөлөгчийн газраа хааж, Булган, Сэлэнгэ аймгуудад шинээр 2 салбар нэмэв.

## 2017 оны гол амжилтууд

2017 он Мерси Кор байгууллагын хувьд ололт, амжилтын томоохон жил болж өнгөрлөө. Бид орон даяар зуданд нэрвэгдсэн өрхүүдэд гамшгийн үеийн тусламжийн багцыг хүргэж, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх хөтөлбөр болох “Даван Туулах, Дасан Зохицох Чадвартай Орон Нутгийн Иргэд” (RCP) хөтөлбөрийг эхлүүлэв. Мөн “Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь 2” төслийг амжилттай хэрэгжүүлсэний үр дүнд “Орон нутгийн даван туулах чадавхийг сайжруулахад уламжлалт болон шинэ технологийг ашиглах нь” (LTT4R) шинэ хөтөлбөрийн санхүүжилтийг баталгаажууллаа. Онцгой Байдлын Ерөнхий Газартай (ОБЕГ) Харилцан Ойлголцолын Санамж Бичиг байгуулсаны үндсэн дээр Мерси Корын Цаг агаарын мэдээлэл хүргэх системийг гамшгаас хамгаалах үндэсний тогтолцоонд нэвтрүүлэн ажиллахаар болов. Төсөл бүрээр гарсан ололтын талаархи дэлгэрэнгүйг доорхи хүснэгтээс харна уу



### » ШИНЭ ТҮНШЛЭЛ

*Мерси Корын Суурин төлөөлөгч Рамеш Сингх Шадар сайд Ө. Энхтүвшинтэй гар барьж байна*

## Үр шим хүртэгчид

### Хүснэгт 2: Төслийн үр шим хүртэгчдийн тоо

Төсөл	Үр шим хүртэгчдийн тоо
Бусад тусламж	4,692
LTS2 (Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь 2 төсөл)	75,708
RCP (Даван Туулах, Дасан Зохицох Чадвартай Орон Нутгийн Иргэд хөтөлбөр)	7,968
<b>Нийт</b>	<b>88,368</b>

2017 онд нийт 88 368 хүн Мерси Корын санхүүжилтээр хийгдсэн сургалт, зөвлөгөө, сургалтын гарын авлага материал, мэдээлэл, засвар нөхөн сэргээлтийн ажлууд, зах зээлийн холбоос болон тоног төхөөрөмжийн зуучлал гэх мэт үйлчилгээнд хамрагдан үр шим хүртсэн байна. Үүнд:

1. Гамшгийн менежментийн талаархи мэдлэг үр чадвараа сайжруулж, цаг агаар, бэлчээрийн мэдээг авч ашиглаж сурсан гамшгаас хамгаалах байгууллага болон төрийн бусад байгууллагуудын боловсон хүчин.
2. Малын эмч - Зарим хувийн мал эмнэлэг болон лабораторийн ажилтнууд сургалтанд хамрагдан үхсэн малд задлан шинжилгээ хийх, бруцеллэз, шүлхий гэх мэт зарим халдварт өвчнийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх мэдлэг чадвараа дээшлүүллээ. Мөн лабораторийн тоног төхөөрөмж, зөөврийн хашаа зэрэг хүлээн авлаа.
3. Малын тэжээлийн үр сонгох, тарих, услах зэрэг газар тариалангийн мэдлэг чадвараа бэхжүүлсэн малчид, малчдын хоршоод.
4. Хонины өлөн гэдсийг боловсруулах сургалтанд сууж, санхүүгийн болон зах зээлд зуучлах үйлчилгээнд хамрагдсан хөдөөгийн иргэд өөрсдийн жижиг бизнесийг эрхлэх боломжтой болсон.
5. Гамшгийн эрсдлийг бууруулах талаархи мэдээлэл авч, мал аж ахуйн чиглэлээр сургалтанд оролцож, цаг агаар, бэлчээрийн мэдээллийг бидний SMS системээр дамжуулан хүлээн авсан малчид.
6. Гүний худаг шинээр барих, өвс тэжээл хадгалах агуулах засварлах, зөөврийн малын хашаа ашиглах зэрэг төсөлд оролцосны үр дүнд амьжиргаагаа сайжруулж, гамшгийг даван туулах чадавхиа бэхжүүлсэн хөдөө орон нутгийн иргэд.
7. Стратеги төлөвлөгөө боловсруулах чадвар эзэмшсэн төрийн албан хаагч, орон нутгийн шийдвэр гаргагчид.
8. Мерси Корын гэрээт зөвлөхүүдтэй хамтран ажиллаж, чадавхиа бэхжүүлсэн малчдын хоршоод.

## Хөтөлбөрийн онцлох үйл явдал

- 2017 оны 4-р сарын 4-ний өдөр бид “Даван Туулах, Дасан Зохицох Чадвартай Орон Нутгийн Иргэд” хөтөлбөрийн албан ёсны нээлтийн үйл ажиллагааг Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Уг арга хэмжээнд төрийн болон олон улсын байгууллагын төлөөлөгчид, малчид гээд 100 гаруй хүн оролцлоо.
- 7 зорилтот аймгийн фермер, малын тэжээл үйлдвэрлэгчдэд 31 тонн тэжээлийн үр нийлүүлж 65 мянган ам долларын үнэтэй 319 тонн овъёос, улаан буудай, арвай, наранцэцэг хураан авлаа. Энэхүү ажил нь газар тариалангийн орчин үеийн технологи нэвтрүүлэх, өвс тэжээлийн эрэлт нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, малчдын байгалийн гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэхэд тодорхой хувь нэмрээ орууллаа.
- Мал аж ахуйн салбарт ажиллаж буй бизнесүүдэд ногоон санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн анхан шатны боловсрол олгох чиглэлээр Хас Банктай Харилцан Ойлголцолын Санамж Бичиг байгуулав.
- 172 малын эмч нар малын өвчин оношлох, вакцинжуулах болон гоц халдварт өвчний тухай ерөнхий мэдлэг олгох сургалтанд хамрагдлаа. Үр дүнд нь малын эмч нар мэдлэг чадвараа сайжруулж, мах, махан бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх, махны экспортын зах зээлийг өргөжүүлэх боломж олгогдлоо.

- Хушаат сумын 2025 он хүртлэх Стратеги төлөвлөгөөг боловсрууллаа. Уг төлөвлөгөөнд төрийн байгууллагуудын зүгээс мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх ажлуудыг нарийвчлан тусгалаа. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсаны дараа тус баримт бичигт орсон ажлуудын шаардагдах санхүүжилтийг төсвөөс гаргах боломжтой болох юм.
- Малчид байгалийн гамшигт хэрхэн бэлддэг, ямар бэрхшээлтэй тулгардаг, гамшигийг даван туулах ямар ур чадвар байгаа эсэхийг тодорхойлох суурь судалгааг 8 зорилтот аймгийн 21 суманд хийв. Тус судалгааг 12-р сарын 18-нд хийж дуусгасан. Судалгааны үр дүн энэ хавар гарах бөгөөд хөтөлбөрийн үр нөлөөг хэмжиж үнэлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.
- Монголын Зээлийн Батлан Даалтын Сантай Санамж Бичиг байгуулан зээлийн барьцаа хөрөнгө дутагдсан хөдөөгийн бизнес эрхлэгчдэд зээлийн батлан даалт гаргах боломж олгохоор тохиров.
- 8 аймгийн 25 малын эмч нарт зориулж шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, хяналт тогтоох мэдлэг олгох сургалт зохион байгуулав. Энэ нь олон улсын зах зээлд мах, мал нийлүүлэх хоригийг цуцлах, мал аж ахуйн хөгжлийг дэмжих, эрүүл, ашиг шим өндөртэй үхэр, хонь, ямаан сүргийг бий болгох чиглэлд хийж байгаа томоохон алхам гэж хэлж болно.
- ОБЕГ болон Ерөнхий сайдын ажлын албатай хамтран гар утасны мессежээр цаг агаарын мэдээ дамжуулдаг үйлчилгээг сайжруулахын тулд холбогдох эрх мэдэл бүхий байгууллага (Мэдээлэл, Харилцаа, Технологийн газар)-аас тусгай зөвшөөрөл авлаа. Үүний үр дүнд:
  - Монголын үүрэн холбооны 4 операторын аль ч дугаараас мессеж авах боломжтой тусгай дугаартай болсон;
  - Систем нь илүү найдвартай, доголдол багатай ажилладаг болсон;
  - Хүсэлт илгээх, хариу өгөх нь илүү хурдан шуурхай болсон;
  - Хязгааргүй мессеж эрхийн үйлчилгээтэй боллоо;
- Мерси Кор ОБЕГ-тай хамтран LTS2 төслийн амжилтыг танилцуулах зорилгоор үндэсний болон орон нутгийн төлөөллийг оролцуулсан Түнш Байгууллагуудын уулзалт зохион байгууллаа.
-

# 1. Даван Туулах, Дасан Зохицох Чадвартай Орон Нутгийн Иргэд Хөтөлбөр (РСР)

## Хөтөлбөрийн тойм

### Санхүүжилтийн хугацаа

2017 оны 4-р сар – 2019 оны 12-р сар

### Зорилтот аймгууд

Архангай, Булган, Хэнтий, Хөвсгөл, Сэлэнгэ, Сүхбаатар, Өвөрхангай, Завхан

### Эрхэм зорилго

Эдийн засгийн хямрал, хүндрэлийг даван туулах чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд оршино

### Зорилтууд

1. Эдийн засгийн зангилаа төв байгуулж залуучуудын оролцоотой, үр ашигтай, эрчимтэй, уян хатан, дасан зохицсон мал аж ахуйн зах зээлийг дэмжих
2. Нийгэм, эдийн засаг, байгаль экологийн хувьсан өөрчлөгдөх нөхцөл байдалд дасан зохицсон орчин үеийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоог хөгжүүлэх
3. Шинэлэг аргаар санхүүжилт, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх замаар эрсдлийг бууруулж, өрсөлдөх чадвартай мал аж ахуйг дэмжих
4. Залуучуудын эдийн засгийн оролцоог нэмэгдүүлсэнээр эдийн засгийн зангилаа төв дэхь залуучуудын ажил эрхлэлтийг сайжруулах

### Хөтөлбөрийн хураангуй

Монгол улсад тулгамдаж буй нийгэм-улс төр, эдийн засаг, байгаль орчны доройтол, бэрхшээл нь хүртээмжтэй, тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж байгаа төдийгүй улмаар малчдын ахуй, амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Тиймээс маш олон жил монголын эдийн засгийн гол тулгуур хүч болж ирсэн мал аж ахуйн салбарыг дэмжих, энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй малчдын даван туулах, дасан зохицох чадварыг сайжруулах зайлшгүй хэрэгцээ бий болсон юм.

Мерси Корын тэргүүлэх эдийн засгийн хөтөлбөр буюу “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөр нь малчид, бизнес эрхлэгчдэд үнэгүй тусламж тараахын оронд өөрийн бизнес, аж ахуйдаа хөрөнгө оруулалт хийх зах зээлийн таатай орчин нөхцөлийг бий болгож байгаа; ЖДҮ-д санхүүгийн шууд тусламж үзүүлэхийн оронд санхүүгийн үйлчилгээг улам хүртээмжтэй болгож байгаа; малчдын аж ахуй, амьжиргааг өөрчлөх гэж хичээхийн оронд тэдний оршдог зах зээлийн тогтолцоог сайжруулах замаар амьдралыг нь өөрчилж байна. Зах зээлийг хөгжүүлэх аргачлал нь зах зээлийн хөшүүрэг, сонирхлыг нэмэгдүүлэх үндсэн дээр малчид иргэдийн бүтээмж, ашиг орлого, амьжиргааг сайжруулахыг зорьдог.



Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагын хувьд Мерси Кор нь тогтвортой, салбар хоорондын уялдаа холбоотой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийн нэмэгдүүлж, хямрал, гамшгийг даван туулах, өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг дэмжих замаар эдийн засгийн хөгжлийг алхам алхамаар бий болгох үүрэгтэй.

Малын тэжээл үйлдвэрлэл, мал аж ахуй, мал эмнэлгийн үйлчилгээ, ногоон санхүүжилт, гамшгийн төлөвлөлт, махны зах зээл, бэлчээрийн менежмент зэрэг салбарт RCP хөтөлбөр ажлаа эхлүүлсэн байгаа. Мэдэгдэхүйц үр дүнг гарахад багагүй хугацаа шаардагдах нь тодорхой. Гэсэн хэдий ч махны өртгийн сүлжээг байгуулах, зах зээлийн үйл ажиллагааг сайжруулах, зах зээлийн тоглогчдын хоорондын ажиллагааг бэхжүүлэх зэрэг бидний ажлууд нь өрхийн орлого нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, хөдөөгийн иргэдийн эдийн засгийн чадавхийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт бид эргэлзэлхгүй байна.

## Үйл ажиллагаа

### Мал үржлийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын төв нээв.

Мерси Кор 2017 оны 9-р сарын 22-нд Сэлэнгэ аймгийн Хушаат сумын төвд Хушаатын Баялаг үржлийн хоршооноос холгүй сургалтын төв байгууллаа. Энд мал үржлийн зөвлөхүүд ирж малчид, зоотехникчид, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд гээд холбогдох бүх талуудад мал үржлийн орчин үеийн арга, туршлагыг заах болно.

Хушаат сумын Соёлын төвд болсон энэхүү арга хэмжээг телевизийн олон сувгаар дамжуулж үзэгчдэд хүргэсэн.

Уг үржлийн төслийн цар хүрээ нь харьцангуй бага ч, цаашид өргөжих боломж ихтэй юм. Ажил нь жигдэрч, үйлчилгээгээ үзүүлээд эхлэхээр бусад үржлийн хоршоо, аж ахуй нэгжүүдэд үржлийн энэхүү загвараас суралцах, туршлага судлах, сурсанаа хэрэгжүүлэх маш том боломж нээгдэнэ. Мөн сургалтын төвд мал аж ахуйн мэргэжилтнүүд ур чадвараа дээшлүүлж, үр дүнд нь малын үүлдэр угсаа, чанар, ашиг шимийг сайжруулах шинэлэг арга барил цаашид нэвтэрч, дэлгэрэх билээ.



Казаккийн цагаан толгойт үхэр, Хушаат аймаг, Сэлэнгэ аймаг

### Орон нутгийн мал аж ахуйн салбарын суурь судалгаа хийв.

2017 оны 8-р сард Мерси Кор нь Хушаатын Баялаг хоршоо болон Хөгнө Мээж зөвлөх багтай хамтран Хушаат суманд өндөр ашиг шимтэй махны чиглэлийн 100 толгой үхрийн цөм сүрэг бий болгох, Казахийн цагаан толгойт үүлдрийн үхрийн чанар, ашиг шим, зах зээлийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэрээ байгууллаа. Үйл ажиллагаага эхлүүлэхийн өмнө Мерси Кор тухайн бүс нутгийн газар зүйн болон нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг сайтар судлах шаардлагатай. 2017 оны 7-р сард Мерси Кор Хушаат суманд суурь судалгаа хийж, үхрийн нас, хүйс, жин, эрүүл мэнд, нөхөн үржих чадвар, орон

нутгийн хоршоодын техникийн чадавхи, бэлчээрийн даац, өвч тэжээл, усны хангамж, нөөц, малчин өрхийн хүн ам зүй (нас, хүйс, малын тоо) зэрэг мэдээллийг цуглууллаа.

Суурь судалгаа нь үндсэн хоёр хэсгээс бүрдсэн. Үүнд: санал асуулга ба өвчний дээжийн шинжилгээ багтсан. Суурь судалгааг эхлүүлэхийн тулд Мерси Кор нь Хөгнө Мээж багтай хамтран малчид, хоршооны гишүүд, сумын удирдлага, мэргэжилтнүүдэд зориулсан 3 багц санал асуулга бэлтгэсэн. Нийт 84 хүн судалгаанд хамрагдсан бөгөөд үүнээс 45 нь Казахстан цагаан толгойт үхэртэй малчид, 18 нь Хушаат Баялаг хоршооны гишүүд, 21 нь сумын төрийн албан хаагчид байв.

Судалгааны үр дүнг 2017 оны 10-р сард Улаанбаатарт дугуй ширээний уулзалтан дээр танилцуулсан. Уулзалтанд Мерси Кор, Хушаатын Баялаг хоршооны төлөөлөл, ХХААХҮ яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Чой-Иш болон бусад холбогдох мэргэжилтнүүд оролцож саналаа солилцлоо.

## **Сумын ИТХ-д Мал үржлийн стратегийн бодлого боловсруулж өгөв.**

Дээрхи судалгааны үр дүнд бид орон нутгийн төрийн байгууллагуудыг чадавхжуулах асуудлыг тусгасан Стратегийн бодлого боловсруулах шийдвэр гаргалаа. Хөгнө Мээж зөвлөх багтай хамтарч боловсруулсан энэхүү баримт бичигт үржлийн орчин үеийн туршлага нэвтрүүлэх нь ашиг шим өндөртэй үхрийн эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хоршоодын чадавхийг бэхжүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, 2025 он гэхэд Хушаат сумын малчид мал үржлийн шинэ арга барилыг эзэмших бүрэн боломжийг нэмэгдүүлэх юм.

2018 оны 1-р сард тус баримт бичгийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд (ИТХ) хүлээлгэн өглөө. Хурлаар батлагдвал хэрэгжилтийн зардлыг орон нутгийн төсөвт тусган цаашид төр болон иргэдийн хараа хяналтанд орж, өөрсдийн нөөц бололцоог ашиглан үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

## **Орон нутгийн малын эмч нарт зориулсан сургалт зохион байгуулав.**

2017 оны 7-8-р сард RCP хөтөлбөр мал эмнэлгийн салбарт үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэллээ. Мерси Кор нь мал эмнэлгийн тэргүүн 4 зөвлөхтэй хамтран 1,5 өдөр үргэлжлэх сургалтыг 8 удаа зорилтот аймаг тус бүрт зохион байгуулав. Сургалтын хөтөлбөрт задлан шинжилгээ, вакцинжуулалт, гоц халдварт өвчин зэрэг сэдвүүд орсон бөгөөд нийт 172 орон нутгийн малын эмч нар (52% нь эмэгтэй, үүнээс 46% нь 35 наснаас доош) сургалтанд оролцлоо.

Сургалтын дараах үнэлгээгээр сургалтанд оролцогчдын мэдлэг 10%-иар нэмэгдэж, 45% нь малын мэс засал, лабораторийн шинжилгээ, оношлогоо гэх өдөр тутмын ажилтай холбоотой сэдвээр цаашид суралцах хүсэлтэй гэдгээ илэрхийлсэн.

## **Шүлхий өвчин сэдвээр сургалт зохион байгуулав.**

Мерси Короос орон нутгийн малын эмч нарт зориулсан чадавхи бэхжүүлэх сургалтыг 10-р сарын 26-нд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Малын өвчний тархалт судлалын холбооны 6 сургагч багшийн удирдлаган доор 20 гаруй малын эмч өвчтэй малыг оношлох, халдварын түвшинг тогтоох, хянах талаар суралцлаа.

Сургалтанд оролцогчид малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар илүү мэдлэгтэй болсон гэдгээ илэрхийлэв. Зарим нь сурсан зүйлээ өөрийн суманд очиж бусдад заана гэж мэдэгдсэн.

Шүлхий өвчний сургалт нь уг өвчний тархалтыг зогсоох төдийгүй, улмаар малын ашиг шимийг нэмэгдүүлэх, өндөр үнэтэй зах зээлд нэвтрэх, олон мянган малчдын амьжиргааг сайжруулах, мал аж ахуйн салбарт ажиллагсдын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэхэд хувь хэмрээ оруулах юм.

### **Малын эмч нарт зориулсан гарын авлага түгээв.**

Бидний зохион байгуулсан сургалтууд хэдийгээр маш үр дүнтэй байсан боловч малын эмч нарын багахан хэсэг л хамрагдаж чадсан. Сургалтанд хамрагдаагүй хэсэгт зориулан Мерси Короос 15 мянган ширхэг мэдээллийн товхимол, 500 видео, “Малын эндемик өвчин” номыг 500 хувь тус тус төрийн болон хувийн мал эмнэлгүүдэд түгээлээ.

Мерси Корын зүгээс дээрхи сургалтын материалуудыг түгээх нь хувийн мал эмнэлгүүдийн чадавхийг сайжруулах төдийгүй, улмаар малчид, малчдын хоршоодод мал эмнэлгийн чанартай үйлчилгээ үзүүлнэ гэсэн хүлээлт байгаа билээ.

### **Орон нутгийн төрийн албан хаагчид стратеги төлөвлөж сурлаа.**

Мерси Кор Сүхбаатар аймагт мал эмнэлгийн сургалт зохион байгуулсанаас хойш удалгүй тус аймгийн ХАА-н газрын мэргэжилтнүүд аймгийн мал эмнэлгийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги боловсруулах чиглэлээр аймгийн хуль тогтоогчдыг сургах хүсэлт бидэнд тавьсан юм.

Мерси Кор улсын тэргүүн хоёр малын эмчийг гэрээгээр ажиллуулж 9-р сарын 10-нд хөгжлийн стратеги боловсруулах сургалт зохион байгуулсан. Нийт 23 малын эмч, төрийн албан хаагчид тус сургалтанд сууж, стратегийн зорилтыг тодорхойлох, нөхцөл байдлыг үнэлэх, багаар ажиллахыг сурлаа. Мөн туршлага багатай оролцогчдод зориулж интернэтээс хэрэгцээтэй мэдээлэл материалаар хангалаа. Тухайлбал барууны орнуудад ижил төстэй стратеги боловсруулсан, хэрэгжүүлсэн тухай түүх, мэдээллийг олж өглөө.

Тус стратегийн бичиг баримт нь батлагдвал Улсын Их Хурлаас гарах шийдвэрийг хүлээхгүйгээр аймгийн ХАА-н газар мал аж ахуйн салбарт нэн даруй ахиц өөрчлөлт, шинэчлэл хийх боломжтой болно. Мерси Корын хувьд бусад аймгууд Сүхбаатарын энэ туршлагыг загвар болгон ашиглаж, өөрсдийн нөөц бололцоогоо дайчлан мал эмнэлгийн үйлчилгээгээ өргөжүүлнэ гэдэгт итгэж байна.

### **Малын өвчний тухай гарын авлага хэвлүүлэн тараав.**

2017 оны 11-р сард Мерси Кор малын эрүүл мэндийн 8 цуврал гарын авлага боловсруулан хэвлүүлэв. Мал эмнэлгийн зөвлөхүүдийн тусламжтайгаар бруцеллёз, шүлхий, некробактериоз (балцруу) гэх мэт малын халдварт өвчнийг хэрхэн таних, урьдчилан сэргийлэх, хянах тухай мэдээлэл бүхий 7 цуврал нь уншигчдын гар дээр хүрээд байна. Харин 8 дахь цуврал нь хүнсний аюулгүй байдал, ариун цэвэр, эрүүл ахуй болон эм, тарилгын үлдэгдлийг малын гаралтай бүтээгдэхүүнээс хэрхэн ангид байлгах талаархи мэдээллийг агуулсан юм.

Мерси Короос нийт 15 мянган гарын авлага мал эмнэлгийн нэгжүүдэд түгээсэн бөгөөд манай зорилтот 11 аймгийн малын эмч нар тус гарын авлагыг хангалттай хэмжээнд авсан хэдий ч зарим нэгжүүд нэмж авах хүсэлт ирүүлээд байна.

### **Мал эмч нарт зориулсан тоног төхөөрөмж нийлүүлэв.**

2017 оны 11-р сард Мерси Кор дараах тоног төхөөрөмжийг худалдан авч нийлүүлэв:

- Малын сэг зэм шатаах зуух – 1 ширхэг (Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн лаборатори)
- Хөргөгч- Хөвсгөл аймгийн 21 мал эмнэлгийн нэгж тус бүрт 1 ширхэг
- Малын эмч нарт зориулсан зөөврийн хашаа - 55 ширхэг (Сүхбаатар, Завхан аймгууд)

Гурван сар хүрэхгүй хугацаанд дээрхи тоног төхөөрөмж нь мал эмнэлэг үржлийн нэгж, лабораториудын халдварт өвчний дэгдэлт болон тархалтыг хянах, урьдчилан сэргийлэх аргыг өөрчилж чадсан билээ. Малын түүхий эд, сэг зэм нь лабораторийн хашаанд булагддаг байсан бол одоо шатаах зууханд устгагддаг болсон. Малын вакцин тарилгыг тасалгааны температурт хадгалдаг байсан бол одоо хөргөгчинд чанарыг алдагдуулахгүйгээр хадгалдаг болсон. Мал сүрэгт тарилга хийх гэж хэдэн өдрийг зарцуулдаг байсан бол зөөврийн хашаатай болсноор 673 400 толгой малыг 14 хоногоос бага хугацаанд тарьдаг болсон. Өмнө нь ийм хэмжээний малыг тарихад дор хаяж 20 хоног зарцуулдаг байв. Вакцинжуулалтыг жилд 3 удаа хийдэг гэж тооцвол зөөврийн хашаатай болсноор цаг хугацаа, шатахуун, ажилчдын хөлс гээд жилд нийт 5,4 сая төгрөг хэмнэх боломжтой боллоо.

Нийт 5 сая мал бүхий 45 мянган малчид мал эмнэлгийн чанартай үйлчилгээ хүртэж чанартай, эрүүл, ашиг шим өндөртэй мал сүрэгтэй болох нөхцөл бүрдэж байна. Энэ туршлагыг бусад орон нутагт нэвтрүүлэхийн тулд Мерси Кор дээрхи нийлүүлсэн тоног төхөөрөмжийн үр ашгийн зардлыг тооцохоор ажиллаж байна. Үр ашгийн тооцоог ХААХҮЯ хүлээн авбал мал эмнэлгүүдэд тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэнэ.

## **Малын тэжээл үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэв.**

2017 оны 4-р сард Мерси Кор малын нэмэгдэл тэжээлийн хэрэгцээ улам бүр өсөж буйг харгалзан 7 аймагт 31 тонн сайн чанарын тэжээлийн ургамлын үр (овьёос, арвай, улаан буудай, царгас, наранцэцэг) нийлүүлсэн юм.

Хэнтий, Хөвсгөл, Завхан гэсэн 3 аймагт малчдын хоршоо, жижиг дунд фермерүүдийг тэжээл тариалах технологийн сургалтанд хамруулсан. Мерси Корын гэрээт агрономчдын тусламжтай хоршоод, фермерүүд тэжээлийн ургамлыг тарих, услах, арчлах, хураах мэдлэг, ур чадвартай боллоо.

9-р сард төслийн хоршоод 160 сая төгрөг буюу 65 мянган ам.доллартай тэнцэх 319 тонн ургац хураан авлаа. Дээрхи ургацыг аймаг, сумын тэжээлийн фондод тушаах, зах зээлийн үнээр борлуулах, өөрсдийн хэрэгцээнд үлдээх гээд олон янзаар ашигласан. Нийт 500 малчид, фермерүүд үрийн тусламжаас шууд болон шууд бус үр шим хүртлээ.

Малын тэжээлийн бизнесээ өргөжүүлэх, шинэ зах зээлд нэвтрэх, илүү үр ашигтай, тогтвортой бизнесийн загварыг бий болгох сонирхолтой жижиг дунд үйлдвэрлэгчдэд Мерси Кор техникийн туслалцаагаа цаашид үзүүлэх болно. Малын тэжээлийн салбарт хөрөнгө оруулахаар малын чанар, эрүүл мэнд нь сайжирч, улмаар хүйтэн өвлийг давах чадвартай, өндөр үнээр борлогдох боломжтой болж байгаа нь малчдын орлого, амьжиргаанд сайнаар нөлөөлнө.

## **Орон нутгийн бизнес эрхлэгчдийг гадны зах зээлтэй холболоо.**

Мерси Кор нь өлөн гэдэс экспортолдог ЕЕСС ХХК-тай хамтран бизнесийг хөгжүүлэх хөтөлбөрийг Булган, Хэнтий, Хөвсгөл, Сүхбаатар, Өвөрхангай, Завхан аймгуудад хэрэгжүүллээ. 2017 оны 5-р

сарын 22-нд байгуулсан Санамж Бичгийн хүрээнд мал аж ахуйн ЖДҮ эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах шинэ боломж нээгдэж байгаа юм.

Тус хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааг 10-р сарын 9-нд Улаанбаатар хотноо ЕЕСС ХХК-ын төв байранд зохион байгууллаа. Сонгогдсон бизнес эрхлэгчид тус компанийн үйлдвэр дээр 45 хоногийн сургалтанд сууж, хүнсний үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдал, бизнес удирдлага, борлуулалт, маркетинг зэрэг сэдвээр суралцана. Одоогоор 8 бизнес эрхлэгч тус сургалтыг төгсөөд байна.

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг (JICA)-ын санхүүжилтийн дэмжлэгтэйгээр дээрхи 8 төгсөгч нь 6 аймагт өлөн цэвэрлэх явуулын цех байгуулахаар төлөвлөж байгаа. Цех бүр ЕЕСС ХХК-д угааж цэвэрлэсэн, анхан шатны боловсруулалт хийгдсэн хонины өлөн гэдэс нийлүүлнэ. Нийлүүлсэн өлөнг хиамны гадна хальсан бүрхүүл болгон ашиглах юм.

Энэхүү нийлүүлэлтийн сүлжээ нь өлөнг олон улсын зах зээлд гаргахаас гадна үнэлэмж багатай гэж тооцогддог түүхий эдийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, 6000 хонины өлөн нийлүүлдэг малчин өрхүүдийн амьжиргааг сайжруулж, бусад үйлдвэрлэгчдэд үлгэр жишээ болох бизнесийн загвар болгон хөгжүүлэхийг зорьж байгаа юм.

## **Суурь судалгаа хийв.**

8 аймгийн 21 суманд нийт 106 мянган малчин өрхөөс санамсаргүй түүврийн аргаар сонгосон 852 малчин өрх суурь судалгаанд оролцлоо. Судалгаанд оролцсон малчин өрхөөс 450 нь манай хөтөлбөрөөс ямар нэгэн байдлаар ашиг тус хүртэнэ гэж хариулсан бол, 400 орчим нь хүртэхгүй байх гэж хариулжээ.

Судалгаанд өрхийн орлогын эх үүсвэр, мал үржил, өрхийн зардал, цаг агаар, байгалийн гамшгийн мэдээлэл, нийгмийн харьцаа, олон нийтийн байгууллага гээд 11 төрлийн асуултууд орсон байгаа. Тус судалгааг бид цаасан хэлбэрээр бус Байгууллагын Сүлжээний Анализ (ОНА) гэдэг гар утасны аппликейшнийг ашиглан авсан. Судалгаа авах сургалтанд оролцсон орон нутгийн ажилтнууд 12-р сарын 18-н гэхэд судалгааг бүрэн хийж дуусгав.

Судалгааны үр дүн энэ хавар гарах бөгөөд бид хөтөлбөрийнхөө явц, үр нөлөөг хэмжих боломжтой болох юм.

## **Монголын Зээлийн Батлан Даалтын Сантай гэрээ байгуулав.**

2017 оны 1-р сарын 13-ны өдөр Мерси Кор Зээлийн Батлан Даалтын Сантай (ЗБДС) Санамж Бичиг байгуулав. Тус Санамж Бичгийн хүрээнд Мерси Кор ЗБДС-тай хамтран барьцаа хөрөнгийн дутагдалтай орон нутгийн бизнес эрхлэгчдэд зээлийн батлан даалтын үйлчилгээг хүргэхээр тохиролцлоо. Мерси Кор нь ЗБДС-ын үйлчилгээг таниулан сурталчлах, махны өртгийн сүлжээний оролцогчдын чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулах, зээлийн батлан даалтын бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах, малчид, мах боловсруулах үйлдвэрүүдийг ЗБДС-ийн үйлчилгээнд хамруулах үүрэг хүлээлээ. Харин ЗБДС нь арилжааны банкуудтай хамтран малчдад зээлийн батлан даалт болон санхүүгийн бусад үйлчилгээг үзүүлэн ажиллах юм байна.

## **ХХААХҮЯ-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулав.**

Мерси Кор байгууллага ХХААХҮЯ-тай хамтран RCP хөтөлбөрийг хэрэгжүүлж, монгол махыг экспортонд гаргахад дэмжлэг үзүүлэхээр тохирлоо. Уг Санамж Бичгийн хүрээнд Мерси Кор болон ХХААХҮЯ нь махны өртгийн сүлжээний оролцогчдод техникийн туслалцаа үзүүлэх, эдийн засгийн зангилаа төв байгуулах, зах зээлийн холбоосыг бэхжүүлэх, малчид, мал эмнэлэг, мал үржлийн алба, мах боловсруулах үйлдвэрүүдийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар боллоо.

## 2. Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь 2 төсөл (LTS2)

### Төслийн тойм

#### Санхүүжүүлэгч байгууллага

АНУ-ын ОУХА-ын харьяа Гамшигт Нэрвэгдсэн Гадаад Орнуудад Тусламж Үзүүлэх Алба (OFDA)

#### Санхүүжилтийн хугацаа

2015 оны 6-р сараас 2018 оны 6 сар

#### Зорилтот аймгууд

Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Дундговь, Говь-Алтай, Хэнтий, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ, Сүхбаатар, Өмнөговь, Увс, Өвөрхангай, Завхан аймгууд

#### Эрхэм зорилго

Эрэлтэд нийцсэн цаг агаарын мэдээллийг хүргэж, орон нутгийн эрсдлийг төлөвлөх болон бууруулах чадавхийг сайжруулсанаар хөдөө орон нутгийн малчид болон эдийн засагт учирдаг зудын эрсдлийг бууруулах; мал маллах тогтолцооны тогтвортой байдлыг урт хугацаанд хангах үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэхэд нь орон нутгийн иргэдийг дэмжиж, 2015-2016 оны зудаас үүссэн сөрөг нөлөөг бууруулах

#### Зорилтууд

1. Цаг агаарын болон бэлчээрийн мэдээллийг малчдад шууд хүргэх мессеж системд суурилсан үндэсний мэдээллийн тогтолцоог бий болгох
2. Онцгой байдлыг төлөвлөх, бэлтгэх, эрсдлийг бууруулах чиглэлийн сургалт зохион байгуулах чадавхийг сум, аймгийн түвшинд бэхжүүлж, орон нутгийн зорилтот бүлгийг сургалтанд хамруулах;
3. “Мал сүрэгт тохиолдсон онцгой байдлын үед баримтлах заавар болон стандартыг” (LEGS) ашиглаж, байгалийн гамшгийн эрсдэлийг тогтвортой бууруулах аргыг орон нутгийн иргэдэд танилцуулж, иргэдэд учирсан зудын хохирлыг арилгах

## Үйл ажиллагаа

### Хөтөлбөрийн хураангуй

Мерси Кор нь Говийн Бэлчээр төслөөр дамжуулан малчид, орон нутгийн иргэдэд бэлчээр, цаг агаарын урьдчилсан нөхцөл байдлын мэдээг хүргэх ажлыг хэрэгжүүлж байсаны үр дүнд 2007 онд Бэлчээрийн Мал Аж Ахуйн Эрсдлийг Урьчилан Мэдээлэх Тогтолцоог (LEWS) анх нэвтрүүлж эхэлсэн юм. Дэлхийн Банк LEWS тогтолцоог дэмжин ажиллуулж байгаа билээ. Үр дүнд нь төрийн хэд хэдэн төрийн агентлагууд цаг агаар болон гамшгийн мэдээ боловсруулж, түгээх үүрэгтэй болсон ч тэдэнд шаардагдах санхүү болон боловсон хүчний нөөц дутагдаж байгаа. Хэрэгцээтэй мэдээ, мэдээлэл гаргаж түгээж байгаа ч малчид, иргэд, төрийн байгууллагуудад төдийлөн хүрч чадахгүй байгаа нь үнэн.

Энэ асуудлыг шийдэхийн тулд 2013 оны 6-р сараас 2014 оны 9-р сарын хооронд Мерси Кор АНУ-ын Гамшигт Нэрвэгдсэн Гадаад Орнуудад Тусламж Үзүүлэх Алба (OFDA)-аас дэмжлэг авч сургалт, мэдээлэл дамжуулах тогтолцоог хөгжүүлэхэд анхаарлаа тавьсан. *Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах төсөл* (LTS) нь гамшгийн эрсдлийг бууруулах болон гамшгийн удирдлагын системд үнэлгээ хийж, иргэдэд цаг агаарын мэдээ хүргэж, орон нутгийн захиргааг онцгой байдлын удирдлагыг төлөвлөх сургалтанд хамруулж, цаг агаарын мэдээ мессежээр хүлээн авах шинэ системийг амжилттай боловсруулж туршлаа.

LTS төсөл нь зуд гэх мэт байгалийн гамшиг, хахир хүйтэн өвөлд бэлдэх, урьдчилан сэргийлэх, төлөвлөх, гарсан хохирлыг бууруулах зэрэг олон төрлийн мэдээллийн хэрэгслийн хэрэгцээ өндөр байгаа гэж таамагласны үндсэн дээр төслөө боловсруулсан. Ийм хэрэгцээ их байсан гэдгийг манай хөтөлбөр амжилттай хэрэгжсэнээр батлагдсан. Орон нутгийн түнш байгууллага, онцгой байдлын удирдах гол байгууллагуудтай хамтран ажилласны үр дүнд LTS төсөл зудаас хамгаалах, бэлдэх, урьдчилан сэргийлэх, цаг агаарын мэдээ хүлээн авах энгийн төлөвлөлт, удирдлагын хэрэгслүүдийг боловсруулж, нэвтрүүлээ. Зудаас хамгаалах, эрсдлийг бууруулахад малчид аль болох олон төрлийн мэдээ мэдээлэл авах сонирхолтой байдаг гэдгийг төсөл хэрэгжих үед батлагдсан.

LTS2 төслийг Мерси Кор ОБЕГ болон ХХААХҮЯ-ны LEWS тогтолцоотой хамтран хэрэгжүүлж байна.

## Цаг агаарын урьдчилсан мэдээлэл хүргэх үйлчилгээ

### ОБЕГ-тай Хамтын Ажиллагааны Санамж Бичиг байгуулав.

2017 оны 5-р сард Мерси Кор ОБЕГ-тай ОУХА-н харьяа OFDA-ийн санхүүжилттэй LTS2 төслийг хамтран хэрэгжүүлэх Санамж Бичигт гарын үсэг зурав. Тус Санамж Бичгийн дагуу хоёр тал онцгой байдал болон гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхийг орон нутагт хөгжүүлэх чиглэлээр хамтран ажилласан юм.

2018 онд уг төсөл хэрэгжиж дуусах үед Мерси Кор цаг агаарын мэдээг хүргэх системийн удирдлага хяналтыг ОБЕГ-т шилжүүлнэ. Мөн Мерси Кор ОБЕГ-тай хамтран “Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд” (LEGS)-тай холбоотой сургалтуудыг зохион байгуулна. Орон нутгийн удирдлагууд, онцгой байдлын комисс, ОБЕГ-н ажилтнууд бүгд сургалтанд оролцоно. Үүнээс гадна аймаг, сумын гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулахад Мерси Кор болон ОБЕГ дэмжлэг үзүүлэн ажиллана.



## **Цаг агаарын мэдээ хүргэх системийн тусгай дугаартай болов.**

2017 онд Мерси Кор нь ОБЕГ, Мэдээлэл харилцаа технологийн газар зэрэг төрийн байгууллагуудтай, Мобиком, Скайтел, Ж-Мобайл, Юнител зэрэг хувийн хэвшилтэй хамтарч цаг агаарын мэдээг мессежээр хүргэх системийн үйл ажиллагааг сайжруулахыг зорин ажиллав. 2017 оны 10-р сард талууд хамтран Санамж Бичиг байгуулж, олон нийтэд зориулсан тусгай дугаарыг (130-105) ашиглалтанд орууллаа. Одоо хэрэглэгчид нэг мессэжийг 50 төгрөгөөр илгээх/хүлээн авах боломжтой болсон. Нэг утаснаас илгээх мессэжийн хэмжээг хязгааргүй болгож, цаашид тусгай гар утсаар дамжуулахгүй мессежээ шууд илгээх боломж нээгдлээ.

## **Цаг агаарын мэдээг хүргэх системийн үр нөлөөг судаллаа.**

2017 оны 1-р сард Мерси Кор цаг агаарын мэдээг мессежээр хүргэх системийг малчдад хэрхэн нөлөөлж байгааг орон нутагт судаллаа. Орон даяар 260 хэрэглэгчийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгаанд хамруулав. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 94% нь уг системийн үйлчилгээнд сэтгэл хангалуун байна гэж хариулсан бол 90% нь цаг агаарын мэдээний нарийвчлал, үнэн зөв байдалд сэтгэл ханамж нь өндөр байна гэжээ. Олонхи нь цаашид зах зээлийн үнэ ханш, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, бэлчээрийн даацын мэдээлэл, цаг агаарын мэдээг 1, 2, 3 долоо хоногоор авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Түүнчлэн малчдаас гадна бусад иргэд уг системийн үйлчилгээг их хэрэглэдэг гэж судалгаагаар гарчээ. Тухайлбал, онцгой байдлын ажилтнууд цаг агаар гэнэт өөрчлөгдөж, гамшиг нүүрлэхэд олон нийтэд сэрэмжлүүлэг хүргэх, нүүлгэх зэрэг шийдвэрээ цаг агаарын мэдээн дээр үндэслэж гаргадаг болсон. Хүний болон малын эмч нар хөдөө орон нутагт ажиллахдаа уг системээс цаг агаарын мэдээ авсаны үндсэн дээр төлөвлөгөөгөө гаргадаг боллоо.

## **ЛТТ4R төслөөр дамжуулж зорилтот аймаг сумдын тоог нэмэгдүүлэв.**

2017 оны 9-р сард Мерси Кор цаг агаарын мэдээг мессежээр хүргэх үйлчилгээгээ 38 суманд шинээр нэвтрүүлээ. 2017 оны 10-р сард эхний туршилт амжилттай хийгдсэний дараа 4 аймаг буюу Архангай, Өвөрхангай, Сүхбаатар, Дорнод аймгууд тус системэнд нэгдлээ.

## **Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд (LEGS)**

### **Чадавхи бэхжүүлэх ажлын үр нөлөөг судаллаа.**

2016 оноос хойш зохион байгуулж байгаа LEGS-ын сургалтын үр нөлөөг үнэлэх судалгааг Мерси Кор 2017 оны 9-р сард гүйцэтгэв. Нийт 126 зорилтот сумын 388 хүн судалгаанд оролцов: сум бүрээс 3 иргэн, 10 аймаг тус бүрээс онцгой байдлын газрын нэг ажилтан хамрагдлаа. Судалгаанд хамрагдагсдын 186 (48%) нь сумын ЗДТГ-аас, 81 (21%) нь мал эмнэлэг, үржлийн албанаас, 19 (5%) нь онцгой байдлын газрын ажилтнууд, 102 (26%) нь иргэдийн төлөөлөл байв. Судалгаанд оролцогсдын ихэнхи нь сумын онцгой байдлын зөвлөлийн гишүүд байлаа.



**Баян-Өлгий аймгийн малчин “Зудын Сургамж” номыг уншиж байна**

Судалгааны гол зорилго нь бидний сургалтууд орон нутгийн гамшгийн бэлэн байдлыг сайжруулахад хэр их нөлөөлдөг, сумын гамшгийн төлөвлөгөө нь зудын хохирлыг багасгахад нөлөөлсөн эсэхийг тодорхойлоход оршиж байсан.

Судалгаанд оролцсон иргэдийн 353 (91%) нь цаг агаарын онцгой нөхцөлд байдалд бэлэн байх явдал өмнөх жилүүдээс эрс сайжирсан, 148 (38%) нь сумын гамшгийн төлөвлөгөө нь өнгөрсөн өвөл малын зүй бус хорогдолын түвшин багасахад сайн нөлөө үзүүлсэн гэж хариулсан байна. Цаашилбал, 169 (43.5%) нь сумынхаа гамшгийн төлөвлөгөөг боловсруулахад оролцож, 124 (39.1%) нь LEGS сургалтыг орон нутагтаа зохион

байгуулсан байна. Мөн 112 (28.9%) нь өөрийн сурсан мэдсэнээ баг, сумын хурлын үеэр танилцуулж мэдээлэл хүргэсэн бол 44 (11.4%) нь цаг агаарын системийн танилцуулга материалыг тараан, хэрхэн цаг агаар, бэлчээрийн мэдээлэл авах тухай зааж сургасан байна.

## **LEGS-ын сургалтын хөтөлбөр олон улсад батлагдлаа.**

2017 оны 9-р сард Мерси Корын хөтөлбөрийн менежер Б. Энхтуяа Өмнөд Африк улсад LEGS-н Сургагч багш бэлтгэх сургалтыг Монголд зохион байгуулах эрхээ албан ёсоор авлаа. Мерси Корын боловсруулсан сургалтын хөтөлбөрийг LEGS-н Олон Улсын Зөвлөл 2017 онд баталж, цаашид уг хөтөлбөрийн дагуу сургалтуудаа явуулахаар болсон. Мерси Кор нийт 1116 хүнийг LEGS-ын хөтөлбөрийн дагуу сургасан. Бид олон сургалтын хөтөлбөрөө орон нутгийн нөхцөлд тохируулж, хөтөлбөртөө гамшгийн эрсдлийн менежмент, гамшгийн төлөвлөгөө, цаг агаарын мэдээг мессежээр авах технологийн тухай сэдвүүдийг нэмж орууллаа.

## **“Зудын сургамж” номыг 6 дахь удаа хэвлэлээ.**

2017 онд “Зудыг давсан зузаан туршлага” номын эрэлт хэрэгцээ тасралтгүй өсөн нэмэгдэв. Өнөөдрийн байдлаар 80 мянган хувийг 17 аймгийн 209 суманд хэвлэн тараасан. Орон нутгийн эрэлт, хэрэгцээ өндөр байсан тул Мерси Кор Монгол Улсын шадар сайд Ө. Энхтүвшингийн үгийг номондоо нэмж, 6 дахь удаа хэвлэлээ. 2017 оны 12-р сард номоо хэвлэж дууссан бөгөөд шинэ онд уншигчдын гар дээр удахгүй хүргэнэ.

## **Иргэдийн даван туулах чадавхийг бэхжүүлэх 10 төслийг санхүүжүүлэв.**

2017 оны 4-5-р сард Мерси Кор 10 дэд тэтгэлэгт төсөл шалгарууллаа (төсөл бүр 50 сая төгрөгөөс хэтрэхгүй). Тэтгэлэгт төсөл бүр малчдын мал сүрэг болон амьжиргааг байгалийн гамшгаас хамгаалахыг зорьсон.

2017 оны 9-р сард доорхи төслүүд амжилттай хэрэгжиж дууссан. Үүнд:

- 16 гүний худгийг засан сэргээх
- 5 гүний худаг шинээр гаргах
- 4 мал угаалгын ванн барих

- 20 малын зөөврийн хашаа барих
- 29 малын хашаа саравч барих
- 14 төрлийн мал эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах
- 5 дальпуу нийлүүлэх
- 2 өвс хадлангийн агуулах засаж сэргээх

Өнөөдрийн байдлаар хөдөө орон нутгийн 22 мянган иргэн, 1,2 сая мал сүрэг Мерси Корын дэд тэтгэлгээс үр шимээ хүртээд байна.

### Тэтгэлэгт төслийн үр шим хүртэгчдийн тоо

Аймгийн нэр	Дэд төслийн нэр	Хүн амын тоо			Малын тоо
		Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	
Ховд	Худаг засварлах, барих	728	330	398	96 950
Архангай	Худаг засварлах, барих	172	85	87	11 000
Завхан	Худаг засварлах, барих	136	72	64	35 870
Увс	Мал эмнэлгийн зөөврийн хашаа	4 063	2139	1 924	411 565
Өвөрхангай	Мал эмнэлгийн зөөврийн хашаа	16 329	8185	8 144	649 658
Хэнтий	Мал эмнэлгийн зөөврийн хашаа	109	50	59	4 585
Архангай	Мал угаалгын банн	175	93	82	24 000
	<b>НИЙТ</b>	<b>21 712</b>	<b>10 954</b>	<b>10 758</b>	<b>1 233 628</b>

### Түнш байгууллагуудын уулзалтыг зохион байгуулав.

Мерси Кор ОБЕГ-тай хамтран түнш байгууллагуудаа 2017 оны 12-р сарын 20-ны Лхагва гаригт Улаанбаатар хотноо урьж, LTS2 төслийн үр дүн, амжилтыг танилцуулах уулзалт зохион байгууллаа. Уг уулзалтанд донор болон хэрэгжүүлэгч байгууллагууд, төслийн үр шим хүртэгчсэд LTS2 төслийн хүрээнд хөдөө орон нутгийн иргэдийн амьдралд гарсан өөрчлөлт, үр нөлөөтэй танилцаж, харилцан ярилцлаа. Уулзалтаар оролцогчдод видео танилцуулга үзүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулах салбарын удирдлагууд үг хэллээ. Тухайлбал Монгол улсын Шадар сайд Ө. Энхтүвшин, ОБЕГ-н дарга, хошууч генерал Т. Бадрал, Мерси Корын Суурин төлөөлөгч Рамеш Сингх, АНУ-н Монгол дахь Элчин сайдын яамны Хэргийг түр хамаарагч ноён Мануэл П. Микаллэр, АНУ-ын ОУХА/OFDA-н Бүсийн зөвлөх Бэн Хэмингуэй зэрэг албаны хүмүүс нээлтийн үг хэлж оролцлоо.

Энэ уулзалтын үр дүнд Мерси Кор, ОБЕГ-ын хамтын ажиллагаа улам бэхжсэн билээ. 2017 онд Мерси Кор ОБЕГ-тай Хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулж, LTS2 төслийн зарим бүрэлдэхүүн хэсгийг өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх шийдвэрийг гаргасан аж. Цаашид ОБЕГ LTS2 төсөлтэй холбоотой бусад арга хэмжээг удирдан хэрэгжүүлэх болно.

# Гамшгаас хамгаалах бусад төслүүд

## Үйл ажиллагааны тойм

### Санхүүжүүлэгч байгууллага

Дэлхийн Хүнс, ХАА-н байгууллага

### Санхүүжилтийн хугацаа

2017 оны 3-р сар

### Зорилтот аймгууд

Баянхонгор, Баян-Өлгий, Ховд, Увс

## Үйл ажиллагаа

### Зуданд өртсөн малчин өрхүүдэд тусламж үзүүлэв.

2017 оны 3-р сард Мерси Кор нь НҮБ-ийн Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагатай хамтран тусламжийн багцыг Баянхонгор, Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн 9 суманд түгээв. Мерси Кор орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран зуданд хамгийн их өртсөн 1084 малчин өрх, 2 цөм сүрэгт тусламжийн багцыг хүргэлээ. Тусламжийн багцанд малын тэжээл (уураг-нүүрстөрөгчөөр баяжуулсан хүчит тэжээл, байгалийн давсан долооц, эрдэс бодис, аминдэм бүхий нэмэлт тэжээл, шинэ төлд зориулсан сүү орлуулагч) болон малд зориулсан анхны тусламжийн хэрэгсэл (2 төрлийн тос, паразитийн эсрэг туулга) багтсан.

## ХОЛБОО БАРИХ

### РАМЕШ СИНГХ

Суурин төлөөлөгч | Мерси Кор Монгол

[rsingh@mercycorps.org](mailto:rsingh@mercycorps.org)

#### Мерси Корын тухай

Мерси Кор нь дэлхий ертөнцийг өөрчлөх боломжтой гэдэгт итгэдэг олон улсын тэргүүний байгууллага юм. Бид 40 гаруй улс оронд зоригтой шийдлүүдийг хэрэгжүүлснээр хүмүүст бэрхшээлийг даван туулах, хөгжихөд нь тусалдаг.

Одоо болон ирээдүйн төлөө.



Мерси Кор АНУ дахь төв:

45 SW Ankeny Street

Portland, Oregon 97204

888.842.0842

[mercycorps.org](http://mercycorps.org)